ТООЛЛОГЫН СУРГАЛТ: Байшин орон сууцны тооллогын Говийн бүсийн сургагч багш бэлтгэх сургалт 2019 оны 9 сарын 14-16-ны хооронд Дундговь аймгийн төвд зохион байгуулагдлаа.

Сургалтыг Дундговь аймгийн Засаг даргын орлогч Ж.Мөнхчулуун, Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл технологийн газрын дарга Л.Мягмарсүрэн нар нээн үг хэлж, МТГ-ын референт Г.Жаргал, ХАОСТТ-ы статистикч И.Цэрэндулам, Р.Батхишиг, Э.Билгүүн нар хичээлийг зааж, Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн хамт олон зохион байгуулан, Говийн бүсийн Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын Статистикийн хэлтсийнхэн, Сайнцагаан суманд ажиллах тоологч нар нийт 25 хүн оролцлоо.



Байшин, орон сууцны тооллогод ажиллах тоологчийг шалгуурын дагуу сонгон шалгаруулан авч нийт 23 хүнийг хамруулан тоологчийн сургалтыг аймгийн төв Мандалговь хотод 2019 оны 9 сарын 19-21-ний хооронд зохион байгууллаа.

Сургалтыг нээж хэлтсийн дарга Б. Энхтуяа тооллогын үзэл баримтлал, зохион байгуулалтын талаар танилцуулж, тоологчдод улсын тооллогод оролцох нэр хүндтэй ажилд хариуцлагатай хандахыг онцолсон юм.



Сургалтын төгсгөлд шалгалтанд хангалттай буюу 80 хувиас дээш үнэлгээ авсан 21 тоологчтой гэрээ байгуулж таблет, тоологчийн багцыг хүлээлгэн өгч, тооллогын ажилд нь амжилт хүслээ.

Мөн Байшин орон сууцны тооллого зохион байгуулах аймгийн комиссын дарга, гишүүд, 15 сумын комиссын дарга, нарийн бичгийн дарга нийт 35 хүнд Байшин орон сууцны тооллогын удирдлага, зохион байгуулалт, анхаарах асуудлууд, Хүн ам орон сууцны тооллого, Байшин орон сууцны тооллого хэрхэн уялдах, явцын мэдээг хэрхэн дамжуулах талаар сургалт, мэдээлэл хийлээ.



Тооллогын явц: 2019 оны 09-р сарын 24-с 10 сарын 12-ны хооронд үргэлжилсэн Байшин орон сууцны тооллогыг 9 сарын 24-ний өдөр албан ёсоор 15 суманд нэгэн зэрэг эхлүүллээ. Үүний дотор Дундговь аймгийн төв Сайнцагаан сум, Говь –Угтаал, Баянжаргалан, Өндөршил сумдад хэлтсийн дарга, мэргэжилтнүүд тоологчийн хамт биечлэн очиж сумдын тооллогын комисст мэдээлэл, чиглэл өгч тооллогын ажлыг

эхлүүлсэн юм. Аймгийн төвийн Сайнцагаан суманд 6 тоологч, Эрдэнэдалай суманд 2 тоологч, бусад сумдад тус бүр 1 тоологч ажиллалаа.



Тооллогын явцын хяналт: 9 сарын 25-наас эхлэн хэлтсийн дарга мэргэжилтнүүд тооллогын хяналтаар 15 суманд хуваарилагдан ажилласан. Тухайн сумдад тооллогын комисстой хамтран нийт өрхийн 10–аас доошгүй хувьд очин хяналт хийхээс гадна, ХАӨМСангийн баяжилт, өрхийн дэвтрийн хөтлөлт, сумдын тооллогын комиссын үйл ажиллагаатай танилцаж заавар зөвөлгөөг өгч ажилласан.

Хяналтаар ажиллахад дараах нийтлэг дутагдал гарч байсан. Үүнд:

Тоологчдын хувьд

- Хашаа хаалганы дугаарыг зөрүүтэй оруулах
- Газар орчны нэрийг латин үсгээр бичих
- Явцын мэдээг зөрүүлэн өгөх
- Тооллогын зорилгыг иргэдэд дутуу танилцуулсан

Сум багийн түр товчоодын хувьд

-Урьдчилсан бүртгэлээр байшингийн төрлийг буруу болон дутуу тэмдэглэсэн
-Өрхөөс асууж буй асуулгыг өмнөөс нь хариулах гэх мэт дутагдлуудыг газар дээр нь залруулан цаашид дээрхи алдааг гаргахгүй тооллогыг амжилттай явуулахыг сум багийн удирдлага тоологч нар анхааруулан ажиллаа. Хэлтсийн мэргэжилтнүүд хуваарь гарган тооллогын явцын мэдээг сум бүрээс авч баталгаажуулан ҮСХ-д хүргүүлж байна.



Тоолох үеийн явцын эцсийн мэдээ, хамралтын хувь: Дундговь аймгийн хувьд 10786 объект тоолохоос нийт 13154 объект тоологдсон ба БОСТ -1-1 3040 буюу 103,6 хувьтай, БОСТ-1-2 9141 буюу 108,3 хувьтай БОСТ-2 82,3 хувьтай мэдээлэл дамжуулагдсан байна. Энд БОСТ-2-н хувьд урьдчилсан бүртгэлээр нийтийн зориулалттай орон сууц гэсэн боловч бодит байдал дээр сууцны тусдаа байшин буюу БОСТ 1-1 байсан учир тоологч шинээр нэмж авсан учраас хамралт дутуу гарсан харагдаж байгаа юм.

Тооллого дууссаны дараа тоологчдоос илтгэх хуудас холбогдох тайланг хүлээн авч тооллогод амжилттай сайн оролцсон 3 тоологчийг урамшуулсан.



Тооллогын урьдчилсан дүн: Дундговь аймгийн хувьд 10734 объект тоолохоос нийт 13154 объект тоологдсоноос БОСТ -1-1 3040 буюу 103,6 хувьтай, БОСТ-1-2 9141 буюу 108,3 хувьтай БОСТ-2 82,3 хувьтай дамжуулагдсан байна. Үүнээс Дундговь аймгийн хэмжээнд хүн байнга амьдардаг сууцны тоо нийт 10186 тоологдсон. Тоологдсон байшин орон сууцыг төрлөөр нь харуулбал : Гэр сууц-8166

Сууцны тусдаа байшин-1718

Бие даасан тохилог сууц -165

Нийтийн байр-45

Нийтийн зориулалттай орон сууц-92

| Аймаг, нийслэл | Сум, дүүрэг | Тухайн өдөр тоологдсон нэгжийн тооллогын асуулгын дугаар | | Тоолвол зохих | | | | | | Бүгд |
|-------------------|------------------|---|------|---------------|---------------|--------------|---------------|------------|--------------|---------------|
| | | | | БОСТ-1-1 | | БОСТ-1-2 | | БОСТ-2 | | |
| | | | | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | |
| Нийт | | | | 3,040 | 103.6% | 9,141 | 108.3% | 124 | 82.3% | 13,154 |
| Дундговь | Бүгд | 1 | 1042 | 3,040 | 103.6% | 9,141 | 108.3% | 124 | 82.3% | 13,154 |
| Дундговь | Сайнцагаан сум | 1 | 1042 | 1,513 | 103.8% | 2,315 | 120.2% | 89 | 94.4% | 4,437 |
| Дундговь | Адаацаг сум | 1 | 812 | 142 | 98.6% | 621 | 105.6% | 0 | 0.0% | 796 |
| Дундговь | Баянжаргалан сум | 1 | 70 | 96 | 90.6% | 272 | 94.1% | 8 | 0.0% | 343 |

| | | | | | | | | | | |
|----------|------------------|---|-----|-----|--------|-------|--------|---|--------|-------|
| Дундговь | Говь-Угтаал сум | 1 | 663 | 134 | 110.4% | 460 | 110.4% | 2 | 100.0% | 658 |
| Дундговь | Гурвансайхан сум | 1 | 617 | 93 | 102.2% | 378 | 119.3% | 4 | 100.0% | 550 |
| Дундговь | Дэлгэрхангай сум | 1 | 715 | 121 | 119.8% | 529 | 107.4% | 9 | 22.2% | 715 |
| Дундговь | Дэлгэрцогт сум | 1 | 481 | 69 | 108.7% | 388 | 101.0% | 4 | 100.0% | 471 |
| Дундговь | Дэрэн сум | 1 | 776 | 83 | 94.0% | 412 | 102.7% | 0 | 0.0% | 501 |
| Дундговь | Луус сум | 1 | 430 | 68 | 100.0% | 260 | 123.8% | 0 | 0.0% | 390 |
| Дундговь | Өлзийт сум | 1 | 648 | 34 | 126.5% | 616 | 94.3% | 2 | 100.0% | 626 |
| Дундговь | Өндөршил сум | 1 | 438 | 97 | 110.3% | 367 | 89.9% | 0 | 0.0% | 437 |
| Дундговь | Сайхан-Овоо сум | 1 | 636 | 104 | 95.2% | 498 | 103.2% | 1 | 200.0% | 615 |
| Дундговь | Хулд сум | 1 | 633 | 104 | 100.0% | 498 | 103.4% | 0 | 0.0% | 619 |
| Дундговь | Цагаандэлгэр сум | 1 | 397 | 59 | 111.9% | 376 | 101.3% | 1 | 0.0% | 447 |
| Дундговь | Эрдэнэдалай сум | 1 | 895 | 323 | 100.3% | 1,151 | 106.3% | 4 | 50.0% | 1,549 |

МАЛ ТООЛЛОГО (Ш6)

Мал тооллогын чанарыг сайжруулахын тулд тооллогын хугацаа богино, төсвийн хүрэлцээ муутай байдаг учраас Банкуудтай хамтран ажиллаж, төсөв хөрөнгө болон хүн хүчийг нэмэгдүүлэн ажиллах талаар санал тооллогын комиссоос гарсныг Монгол банкинд уламжлан, хамтран ажиллах талаар болон малын А дансыг банкууд зээл олгохдоо малчдаас шаарддаг бөгөөд, Багийн Засаг дарга нараас авч хуулбарыг банкинд өгөхдөө урах, муухай болгох зэрэг баримтын чанарыг алдагдуулдаг тул малчдын малын тооны мэдээллийг Монгол банкны мэдээллийн сангаас гарган авч, малчдаас нэхэхгүй байхаар зохицуулалт хийж өгөх талаарх саналуудыг хүргүүлэн ажилласан.

ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 05 сарын 16-ны өдрийн 01/421 тоот албан бичгийг үндэслэн аймгийн хэмжээнд хагас жилийн мал тооллогын ажлыг 6 сарын 3-наас 10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Мөн Аймгийн Засаг даргын 2019 оны 05 сарын 21-ны өдрийн 1/652 тоот албан бичгийг бүх сумдын Засаг даргад хүргүүлж, мал тооллогын бэлтгэл ажлыг хангаж, тооллогод ажиллах тоологч нарын сургалтыг сумандаа зохион байгуулж, маршрут төлөвлөгөө гаргуулан ажиллах талаар чиглэл өгсөн.

2019 оны 6 сарын 3-ны өдрийн хэлтсийн даргын Хагас жилийн малын түүвэр судалгааны хяналтыг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу Гурвансайхан, Өндөршил, Дэлгэрцогт, Адаацаг, Өлзийт, Луус, Хулд сумдад хэлтсийн дарга, мэргэжилтнүүд ажиллалаа. Ажиллах хугацаандаа сумдын тооллогын захирамж, маршрут, төлөвлөгөө, тооллогын зохион байгуулалт, маягтыг алдаагүй бүрэн бөглөсөн эсэх, шивэлтийг алдаагүй зөв шивэх талаар заавар, зөвлөмж өгч, 5-10 өрхөөр орж мал тооллогын маягтыг тулгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 83 өрхөд очиж хяналт хийсэн бол 39 өрхийн маягтын бөглөлт, 25 өрхийн программ дахь шивэлт дээр өмнөх оны А данстай тулган шалгаж нийт 147 өрхөд хяналт хийлээ.



Аймгийн хэмжээнд 15 сумын 68 багийн 1362 өрх сонгогдож 90 тоологч, 30 жолооч нийт 120 хүн ажиллалаа.

ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ ТООЛЛОГО

Ш6.1 Тооллогын мэдээллийн чанар:Жилийн эцсийн мал тооллогын албан тоотыг аймгийн Засаг даргаар батлуулан 15 сумдад хүргүүлж ажиллалаа. Мал тооллого зохион байгуулах аймгийн комиссыг аймгийн Засаг даргаар ахлуулан, нарын бичгийн даргаар статистикийн хэлтсийн дарга, гишүүд нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баталж комиссын хурлыг 12 сарын 6-ны өдөр зохион байгуулж аймгийн хэмжээнд 2019 оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг чанартай зохион байгуулах, сумдад хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгүүдийг шинэчлэн баталлаа.

2019 оны 12 сарын 4-нд сумдын иргэдийн хурлын дарга, Засаг дарга, Төрийн сангийн мэргэжилтнүүдэд нийт 45 хүнд сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар Статистикийн хэлтсийн дарга, Хэлтсийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн нар хичээл зааж, сумдад мал тооллогын чанартай зохион байгуулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан.



Ш6.2 тооллогын хяналт:Мал тооллогын хяналтаар 15 суманд 5 хэсэг 25 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, сум тус бүр 5-10 өрхийг нэг бүрчлэн тоолж, сумдын мал тооллогын комиссын үйл ажиллагаатай танилцаж, А дансыг нэг бүрчлэн шалгаж заавар зөвлөмж өгч ажиллаа. Сумдын мал тооллогын комисс ажлын хэсгүүддээ хяналт тавьж хэсэ бүр 8-10, сумдын хэмжээнд 45-50 өрхөөр хяналт хийж ажиллаа. Нийт аймгийн хэмжээнд 20 хэсгийн 105 хүн 870 өрхөд хяналтын тооллого зохион байгууллаа



Ш6.3.Тооллогын мэдээллийн дамжуулалт: Мал тооллогын шивэлтийг 15 сумын 68 багийн Засаг дарга нарболон мал тооллогын хэсгийн зарим ажилчид хийж байна. Шивэлтийн явцад хяналт тавьж, зааж зөвлөж ажиллаж байна.

7. ӨРХИЙН НИЙГЭМ,ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА /Ш-7/

2019 онд ҮСХ-ноос баталсан мэдээ тайлангийн графикайн дагуу ӨНЭЗСудалгааны түүврийн нэгжийг ҮСХ-ноос авч, судалгаанд сонгогдсон өрхөөр биечлэн очиж /сард хөдөөгийн болон сумын төвийн өрхөд 1 удаа, аймгийн төвийн өрхөд дунджаар 3-5 удаа/ судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж, өрхийн хүнсний хэрэглээний дэвтэрүүдээ тарааж, судалгааг тогтсон аргачлал, зааврын дагуу таблетаар авч, мэдээллийг бүрэн цуглуулж байна.

Мэдээлэл цуглуулсныхаа дараа судалгааны асуулгыг үзүүлэлт бүрээр нь нэг бүрчлэн шалгаж нягтлан, хоорондын уялдаа холбоо, орлого зарлагыг тооцож ажил мэргэжлээр кодолж, алдаагүй үнэн зөв мэдээллийг графикт хугацаанд нь ҮСХ-д дамжуулж байна. Энэхүү дамжуулсан мэдээг ахлагч татан авч, нэг бүрчлэн шалгаж, алдаатай буюу асууж тодруулах шаардлагатай зүйлүүдийг тодруулан засч ҮСХ-нд 100 хувь дамжуулдаг.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд 2019 онд нийт өрх-312 хамрагдаж, үндсэн өрх-284, нөөц өрх-28 тус тус хамрагдсан.

Аймгийн төв болон хөдөөгийн сонгогдсон өрхүүдийн зарим нь хаягандаа байхгүй өөр аймаг суманд шилжин суурьших, түр хугацаагаар ажиллах, цаг агаарын байдлаас шалтгаалан отроор нүүх, ахмад настнууд өөр аймаг сум, хотод болон гадаадад хүүхдүүд дээрээ очиж амрах, хүүхдийг нь харах, гэр бүлийн хүнээ эмчлүүлэхээр түр хугацаагаар эзгүй явах зэрэг шалтгаанаар нөөц өрхийг судалгаанд хамруулж байна. Тухайн сонгогдсон өрхийн мэдээлэл ХАӨМС-н программ дахь мэдээлэлтэй зөрүүтэй байсан тохиолдолд багийн Засаг даргад хандаж засуулж хэвшсэн.

Мөн өрх тус бүрт урамшууллын мөнгийг тарааж гарын үсэг зуруулж баталгаажуулж байна. Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгаанд хамрагдсан өрхүүдийн өдрийн тэмдэглэлийн хөтөлгөөг сар бүр архивлан хадгалж байна.

Ардчилсан засаглалын судалгаа: ҮСХ-ны баталсан графикайн дагуу АЗС-ны мэдээг улирал болгон судлаач нар дамжуулж, ахлагч мэдээг нэг бүрчлэн хянаж, алдаа гарвал засуулж ҮСХ-нд хугацаанд нь 100 хувь дамжуулж байна.

АЗС-ны өрхийн жагсаалтыг сонгогдсон багуудаас улирал бүр авч нэгтгэн, ҮСХ-д дамжуулдаг. Бидний явуулсан жагсаалтаас судалгаанд сонгогдсон өрхийн нэрс ирж, уг өрхүүдээс улирал бүр судалгааг авч байна.

Ардчилсан засаглалын судалгаанд 2019 оны 2, 5, 8, 11-н саруудад нийт 72 өрх сонгогдож, өрхөд биечлэн очиж судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж өрх тус бүрт урамшууллын мөнгийг бүрэн өгч гарын үсэг зуруулж баталгаажуулж хэвшсэн. Судалгааг тогтсон аргачлалын дагуу таблетаар бүрэн гүйцэд авч байна. Мэдээлэл цуглуулсны дараа судалгааны асуулгыг шалгаж нягтлан, хугацаанд нь дамжуулж байв.

Хэрэглэгчийн төлөв байдлыг тодорхойлох судалгаа: ҮСХ-ны баталсан графикайн дагуу ХТБТС-ны мэдээг улирал болгон судлаач нар дамжуулж, ахлагч мэдээг нэг бүрчлэн хянаж, алдаа гарвал засуулж ҮСХ-нд хугацаанд нь 100 хувь дамжуулж байна.

ХТБТС-ны өрхийн жагсаалтыг сонгогдсон багуудаас улирал бүр авч нэгтгэн, ҮСХ-д дамжуулдаг. Бидний явуулсан жагсаалтаас судалгаанд сонгогдсон өрхийн нэрс ирж, уг өрхүүдээс улирал бүр судалгааг авч байна.

Хэрэглэгчийн төлөв байдлыг тодорхойлох судалгаанд 2019 оны 1, 4, 7, 10-н саруудад нийт 72 өрх сонгогдож, өрхөд биечлэн очиж судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж өрх тус бүрт урамшууллын мөнгийг бүрэн өгч гарын үсэг зуруулж баталгаажуулж хэвшсэн. Судалгааг тогтсон аргачлалын дагуу таблетаар бүрэн гүйцэд авч байна. Мэдээлэл цуглуулсны дараа судалгааны асуулгыг шалгаж нягтлан, хугацаанд нь дамжуулж байв.

8.АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА /Ш-8/

ҮСХ-ны баталсан графикайн дагуу АХС-ны мэдээг сар болгоны 1-нд судлаач нар дамжуулж, ахлагч мэдээг нэг бүрчлэн хянаж, алдаа гарвал засуулж дараа сарын 5-нд ҮСХ-нд хугацаанд нь 100 хувь дамжуулж байна.

АХС-ны өрхийн жагсаалтыг сонгогдсон багуудаас сар бүрийн 20-нд авч нэгтгэн, ҮСХ-д 25-ны дотор дамжуулдаг. Бидний явуулсан жагсаалтаас судалгаанд сонгогдсон өрхийн нэрс ирж, уг өрхүүдээс сар бүр судалгааг авч байна. Судалгаанд сонгогдсон өрхөд биечлэн очиж судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж өрх тус бүрт урамшууллын мөнгийг бүрэн өгч гарын үсэг зуруулж баталгаажуулж хэвшсэн. Судалгааг тогтсон аргачлалын дагуу таблетаар бүрэн гүйцэд авч байна. Мэдээлэл цуглуулсны дараа судалгааны асуулгыг үзүүлэлт бүрээр нэг бүрчлэн шалгаж нягтлан, хоорондын уялдаа холбоо, орлогыг тооцож ажил мэргэжлээр нь кодолж, хугацаанд нь дамжуулж байв.

2019 нийт 640 өрх сонгогдсоны, үндсэн өрх-589, нөөц өрх-51 тус тус хамрагдсан.

Багийн Засаг дарга нар нэрсийн жагсаалтаа өгөхдөө шилжсэн, нас барсан, түр хугацаагаар болон удаан хугацаагаар эзгүй байгаа, отроор нүүж яваа өрхүүдээ тайлбарт тусгайлан тодруулж өгч байгаа боловч тус аймгийн иргэд Улаанбаатар хот Өмнөговь аймаг зэрэг үйлдвэр, уул уурхай ихтэй суурин газарт түр хугацаагаар эмчлүүлэхээр болон ажил хийхээр явах нь элбэг байгаа зэргээс шалтгаалж нөөц өрх сонгогдож байна.

Хүснэгт.6. Өрхөд суурилсан түүвэр судалгааны хамралт

| | | |
|-----|------------------------------|----------|
| д/д | Ш7.1 ӨНЭЗ судалгааны хамралт | 100 хувь |
| 1 | Хамрагдвал зохих өрхийн тоо | 312 |
| | Нөөц өрхийн тоо | 28 |
| | Үндсэн өрх | 284 |
| 2 | Ш8.1 АХС хамралт | 100 хувь |
| | Хамрагдвал зохих өрхийн тоо | 640 |
| | Нөөц өрхийн тоо | 51 |
| | Үндсэн өрх | 589 |

9.ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА /Ш-9/

Цаг ашиглалтын судалгаа

ҮСХ-ноос 5 жил тутам зохион байгуулагддаг Цаг ашиглалтын судалгаа энэ жил Дундговь аймагт зохион байгуулагдаж байна. ЦАС-ны ахлагч, судлаачдад зориулсан сургалт 3 дугаар сарын 13-14-ны хооронд ҮСХ-нд болж ахлагч судлаач нар бүрэн хамрагдлаа.

Сургалтаар анхан шатны мэдээлэл цуглуулдаг судлаач нар, түүнийг хянаж шалгаж байдаг багийн ахлагч нарт ЦАС-ны асуулгыг зааврын дагуу үнэн, зөв, бүрэн, чанартай нөхөх чадвар эзэмшүүлэх, тэднийг нэгдсэн нэг ойлголттой болгох, судалгааны ярилцлага авах чадварыг дээшлүүлэх, асуулгын үзүүлэлт бүрийг нягт ойлгож, зөв нөхөх чадвартай байх зэрэг олон талын мэдлэг, мэдээлэл өглөө.

Цаг ашиглалтын судалгаанд 1-р улиралд нийт-60 өрх судалгаанд хамрагдах байснаас цаг үеийн байдлаас хамаарч үндсэн 55 өрх, хаяган дээрээс 5 өрх судалгаанд хамрагдав. 2-р улирлын байдлаар нийт 60 өрх хамрагдсанаас үндсэн өрх-53, нөөц хаяган дээрээс 7 өрх судалгаанд хамрагдсан. 3-р улиралд нийт-60 өрх судалгаанд хамрагдах байснаас цаг үеийн байдлаас хамаарч үндсэн 56 өрх, хаяган дээрээс 4 өрх судалгаанд хамрагдав. 4-р улирлын байдлаар нийт 60 өрх хамрагдсанаас үндсэн өрх-52, нөөц хаяган дээрээс 8 өрх судалгаанд хамрагдсан. Бүтэн жилийн байдлаар нийт өрх-240, үндсэн өрх-216, хаяган дээрээс 24 өрх тус тус хамрагдсан.

Судалгааг нийт 240 өрхөөс судалгааны мэдээллийг цуглуулан шивж ҮСХ-нд дамжуулсан.

Хүснэгт.7. Эдийн засгийн түүвэр судалгааны хамралт

| | | |
|-----|-------------------------------|----------|
| д/д | Ш9.1 ЦАС хамралт | 100 хувь |
| 1 | Хамрагдвал зохих өрхийн тоо | 240 |
| 2 | Хаяган дээр байгаа өрхийн тоо | 24 |
| 3 | Үндсэн өрх | 216 |

Олон хэмжээст ядуурлын үзүүлэлт тодорхойлох туршилтын судалгаа

Олон хэмжээст ядуурлын индексийн зорилго нь ядуурлыг бууруулах бодлогын үр нөлөөг олон талаас нь тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын бодлого боловсруулах суурь мэдээлэл бий болгоход чиглэсэн юм.

Судалгаанд ҮСХ-ноос 2018 онд зохион байгуулан явуулсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд хамрагдсан 16’488 өрхөөс 1’132 өрхийг түүвэрлэн сонгосон. Дундговь аймгаас ӨНЭЗСудалгаанд хамрагдсан 624 өрхийн 208 өрхийг түүвэрлэн

Танилцуулгыг PDF болон PPT хэлбэрт оруулан хэлтсийн вэб хуудас болон аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн программ ABLE-д олон нийтийн хэсэгт байршуулан нийт 15 сум, төрийн захиргаа болон үйлчилгээний нийт 48 байгууллагын 728 албан хаагчид нэгэн зэрэг хүргэдэг.

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *[Signature]* Б.ЭНХТУЯА

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2019 ОНЫ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Сар | Сар бүрийн танилцуулгаар олон нийтэд мэдээлэл хийх | Хариуцах эзэн | Тооллого судалгааны сурталчилгаа | Хариуцах эзэн | Бусад үйл ажиллагаа | Хариуцах эзэн | | |
|-----|--|-----------------|--|--|--|---|---|--|
| 1 | 1-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Г.Ариунжаргал | Жендерт суурилсан хүчирхийлэл судалгааны үр дүнг тархаах | Б. Энхтуяа Т. Бямбасүрэн | Хэлтэс агентлаг, төрийн бус байгууллагууд иргэдэд www.1212.mn сайтыг сурталчилан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, Ширээний хуанли бэлтгэн тархаах, Хяналтын самбар бэлтгэх | Т. Бямбасүрэн С. Доржханд Н. Түвшинжаргал, Б. Отгонсүрэн | | |
| 2 | 2-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | С. Доржханд | | | Улирлын статистик үзүүлэлтээр болон тэмдэглэлт баяр ёслолын үзүүлэлтүүдээр инфографик, өврийн дэвтэр бэлтгэн хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаах | Н. Түвшинжаргал Б. Отгонсүрэн болон холбогдох мэргэжилтэнүүд | | |
| 3 | 3-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Н. Түвшинжаргал | | 2019 онд зайлшгүй хийж 4 танилцуулгыг хийж тархаах (Хөдөө аж ахуй, Өрх хүн ам, Ажил эрхлэлт, Ам үйлдвэр) | Т. Бямбасүрэн С. Доржханд Н. Түвшинжаргал | Өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр танилцуулга сургалт зохион байгуулах, гарын авлага бэлтгэн тархаах, | Б. Энхтуяа Г. Болормаа Б. Мижиддорж Д. Номинзул | |
| 4 | 4-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Б. Отгонсүрэн | | | | Улирлын статистик үзүүлэлтээр болон тэмдэглэлт баяр ёслолын үзүүлэлтүүдээр инфографик бэлтгэн хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаах | Н. Түвшинжаргал Б. Отгонсүрэн болон холбогдох мэргэжилтэнүүд | |
| 5 | 5-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Т. Бямбасүрэн | | | 7-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Б. Энхтуяа Т. Бямбасүрэн С. Доржханд Н. Түвшинжаргал | 2018 оны жилийн эцсийн танилцуулгыг сүүлийн 10 жилээр харьцуулан гаргаж хэрэглэгчдэд тархаах, сумдын 10 жилийн танилцуулгыг бэлтгэх тархаах | Б. Энхтуяа Т. Бямбасүрэн С. Доржханд Н. Түвшинжаргал Г. Ариунжаргал Б. Отгонсүрэн |
| 6 | 6-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Н. Түвшинжаргал | | | | | | |


| | | | | | | | | | | |
|----|---|-----------------|---|--|---|--|---|--|--|--|
| 7 | 7-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Б. Отгонсүрэн | Байшин орон сууцны тооллого-2019 судалгааны сурталчилгааны ажил | Б. Энхтуяа Н. Түвшинжаргал | 2018 оны жилийн эцсийн танилцуулгыг сүүлийн 10 жилээр харьцуулан гаргаж хэрэглэгчдэд тархаах, сумдын 10 жилийн танилцуулгыг бэлтгэх тархаах | Б. Энхтуяа Т. Бямбасүрэн С. Доржханд Н. Түвшинжаргал Г. Ариунжаргал Б. Отгонсүрэн | | | | |
| 8 | 8-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Н. Түвшинжаргал | | | | | Улирлын статистик үзүүлэлтээр болон тэмдэглэлт баяр ёслолын үзүүлэлтүүдээр инфографик бэлтгэн хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаах | Н. Түвшинжаргал Б. Отгонсүрэн болон холбогдох мэргэжилтэнүүд | | |
| 9 | 9-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Т. Бямбасүрэн | Хүн ам орон сууцны тооллого-2020 тооллогын сурталчилгааны ажил | Б. Энхтуяа Т. Бямбасүрэн С. Доржханд | Статистикийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ойн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах, Мэдээлэгч байгууллагуудын дунд сурталчилгааны ажил зохион байгуулах | Хэлтсийн ажиллагчид бүгд | | | | |
| 10 | 10-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | С. Доржханд | | | | | Улирлын статистик үзүүлэлтээр болон тэмдэглэлт баяр ёслолын үзүүлэлтүүдээр инфографик бэлтгэн хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаах | Н. Түвшинжаргал Б. Отгонсүрэн болон холбогдох мэргэжилтэнүүд | | |
| 11 | 11-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Б. Отгонсүрэн | | | | | 12-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Т. Бямбасүрэн | | |
| 12 | 12-р сарын нийгэм эдийн засгийн танилцуулгыг гарган тархаах, АС, Цогцолбороор мэдээлэл хийх | Т. Бямбасүрэн | | | | | | | | |

Төлөвлөгөө боловсруулсан:


[Signature]

Мэргэжилтэн С.Доржханд

Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс



Мөн сар бүрийн танилцуулга, цаг үеийн ажил, тооллого судалгааны талаарх мэдээллийг Засаг даргын дэргэдэх Ард телевиз, аймгийн онцгой байдлын газрын АС цогцолбор буюу шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн радиогоор мэдээлж олон нийтэд сар бүр мэдээлэл хийсэн байна.





Хүснэгт .8. Радио, телевиз, сонин хэвлэлээр статистикийн мэдээллээ танилцуулж, сурталчилсан ажил

| | Тархаасан мэдээллийн агуулга | Хариуцсан ажилтан | Хугацаа | тоо | Хэвлэл мэдээллийн агентлагийн нэр |
|---|--|---|------------|-------|---|
| 1 | “2018 оны мал тооллогын дүн ” | Б.Энхтуяа | 2019.01.08 | 3 | Засаг даргын дэргэдэр “Ард” телевиз |
| 2 | “Аймгийн нийгэм эдийн засгийн байдал” сар бүрийн танилцуулга | Т.Бямбасүрэн С.Доржханд Б.Отгонсүрэн Н.Түвшинжаргал Н.Тамжидмаа | Сар бүр | 12 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” Шуурхай удирдлагын зарлан мэдээлэх төв |
| 3 | Жэндэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үр дүн хэлэлцүүлэгийн тухай | Н.Должинсүрэн | 2019.02.25 | 1 | Засаг даргын дэргэдэх “Ард” телевиз |
| 4 | Хүн ам орон сууцны тооллогын тухай | Т.Бямбасүрэн | 2019.2.27 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 5 | Цаг ашиглалтын судалгаа | С.Доржханд | 2019.03.18 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 6 | 2018 оны жилийн эцсийн инфографик, ХАА-н инфографик | Хэлтсийн нийт ажилчид | 2019.02.10 | 500 ш | Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт цаг үеийн сонин |
| 7 | Хэлтсийн танилцуулга, 2018 оны хүн ам, ХАА инфографик | Хэлтсийн нийт ажилчид | 2019.03.25 | 50ш | Аялгуут нутаг сэтгүүл |

Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

| | | | | | |
|----|--|---------------------------|------------|----|---|
| 8 | 2018 оны өрх хүн ам нийгмийн зарим үзүүлэлтийн танилцуулга | С.Доржханд | 2019.05.16 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 9 | 2018 оны өрх хүн ам нийгмийн зарим үзүүлэлтийн танилцуулга | Статистикийн хэлтэс | 2019.06.13 | 1 | Засаг даргын дэргэдэх “Ард” телевиз |
| 10 | 2018 оны Хөдөө аж ахуйн танилцуулга | Н.Түвшинжаргал | 2019.06.19 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 11 | 2018 оны Аж үйлдвэр барилгын салбарын танилцуулга | Т.Бямбасүрэн | 2019.06.25 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 12 | 2018 оны Аж үйлдвэр барилгын салбарын танилцуулга | Статистикийн хэлтэс | 2019.07.17 | 1 | Засаг даргын дэргэдэх “Ард” телевиз |
| 13 | Байшин орон сууцны тооллого зохион байгуулагдах талаар цаг үеийн мэдээ | Т.Бямбасүрэн | 2019.09.17 | 1 | Засаг даргын дэргэдэх “Ард” телевиз |
| 14 | Байшин орон сууцны тооллого зохион байгуулагдах талаар цаг үеийн мэдээ | Т.Бямбасүрэн | 2019.09.23 | 1 | Онцгой байдлын газрын “АС цогцолбор” мэдээллийн радио |
| 15 | Хүн ам орон сууцны тооллогын тухай registration.nso.mn | Б.Энхтуяа Т.Бямбасүрэн | 2019.12.09 | 1 | Засаг даргын дэргэдэх “Ард” телевиз |
| | Дүн | | | 26 | |

Хүснэгт.9. Статистикийн албыг олон нийтэд сурталчилж зохион байгуулсан нээлттэй өдөрлөг, уулзалт

| | Сэдэв | Зохион байгуулсан ажилтан | хийсэн хугацаа | Оролцсон | |
|---|--|---------------------------|----------------|-----------|------------------------------------|
| | | | | хүний тоо | Байгууллага, ажилтан |
| 1 | “Хөдөлмөрийн статистикийн шинэчилсэн аргачлал” | Т.Бямбасүрэн | 2019.01.23 | 18 | Аймгийн ХХҮГ |
| 2 | “2018 оны оны жилийн эцсийн аймгийн нийгэм эдийн засгийн мэдээлэл” | Т.Бямбасүрэн | 2019.01.29 | 12 | Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс |

| | | | | | |
|---|--|--|---------------------------|-----|--|
| 3 | Сар бүрийн статистик мэдээллийн танилцуулга | Т.Бямбасүрэн С.Доржханд Б.Отгонсүрэн | Сар бүрийн 12-14 өдрүүдэд | 170 | Аймгийн ЗДТГ-ын ОНХАлбаны мэдээллийн самбараар иргэдэд |
| 4 | ХАОСТ-2020, БОСТ-2019 болон цаг үеийн бусад мэдээллээр | Б. Энхтуяа | 2019.05.13 | 60 | Аймгийн төр захиргааны бүх байгууллагын дарга нар |
| 5 | Байшин орон сууцны тооллого болох тухай урьдчилсан бүртгэл хийх тухай | С.Доржханд Н.Түвшинжаргал | 2019.06.25 | 25 | Сайнцагаан сумын ЗДТГ |
| 6 | 95 жилийн ойд зориулсан Нээлттэй мэдээллийн өдөрлөг | Хэлтсийн хамт олон | 2019.10.21-28-ны өдрүүд | 125 | Аймгийн ЗДТГ, Сайнцагаан сумын ЗДТГ |
| 7 | 2020 оны Хүн ам орон сууцны тооллого болон 2019 оны Мал тэжээвэр, амьтад хашаа худгийг тооллогын зохион байгуулалт | Б.Энхтуяа | 2019.12.09 | 60 | Аймгийн төр захиргааны бүх байгууллагын дарга нар |
| | Бүгд | | | 470 | |

Ш10.2 Тооллого, судалгааны сурталчилгаа

1. Үндэсний статистикийн хороо, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2017 онд жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгааг улс орон даяар анх удаа зохион байгуулж, 2018 оны 6-р сард үр дүнг улсын хэмжээнд танилцуулсан юм. Тус аймагт "Жендэрт суурилсан хүчирхийлэл" үндэсний судалгааны үр дүнг танилцуулах семинар 2019 оны 2 сарын 25-нд амжилттай зохион байгуулагдсан. Семинарт аймгийн БСУГ, ГБХЗХГ-ын холбогдох ажилтнууд, аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, аймгийн төв Сайнцагаан сумын багийн засаг дарга, нийгмийн ажилтнууд, төрийн бус байгууллагын төлөөллүүд оролцож хэлэлцүүлэг өрнүүлж, цаашид Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагууд хамтран ажиллахаар болсон.



Энэ ажлын хүрээнд “Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны үр дүнг танилцуулах сургалтанд оролцсон байгууллагуудаас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор “Эмэгтэйчүүдийн эв нэгдлийн хана” сэдэвт үйл ажиллагааг зохион байгуулж улмаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ААНБ-ын албан хаагчид, иргэдийн тайван алхалт зохион байгууллаа. Статистикийн хэлтсийн хамт олон тус үйл ажиллагаанд “Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны үр дүнг сурталчлан оролцсон юм.





2. Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Дэлгэрцогт, Сайнцагаан, Адаацаг, Өлзийт, Луус сумдын тооллогын комисс болон түр товчооны гишүүд, сумдын төрийн албан хаагчдад мэдээлэл хийж, харьяа багийн даргадаа хандаж ХАӨМС-ийн мэдээллээ шинэчлэхийг зөвлөж ажиллалаа.

Мөн Дундговь аймгийн Ард телевизээр 2020 оны ээлжит тооллого хэрхэн зохион байгуулагдах, Байшин орон сууцны тооллогын талаар мэдээлэл өглөө. Дундговь аймгийн Ард телевиз нь тус аймгийн 45000 иргэд олон нийтэд цацагдахаас гадна ДДЭШ кабелийн телевизээр орон даяар цацагддаг юм.




Мөн иргэд олон нийтэд Ард телевиз болон Монцамэ агентлагийн Дундговь дахь сэтгүүлч Дундговийн амьдрал сонинуудаар дамжуулан ХАӨМС дахь өөрийн мэдээллээ багийн Засаг даргадаа хандан шинэчлүүлэхийг уриалж байна.

3. Байшин орон сууцны тооллогын сурталчилгаа

Хүн ам орон сууцны тооллогоос анх удаа тусдаа зохион байгуулагдаж буй Байшин орон сууцны тооллогын сурталчилгааг дараах байдлаар хийлээ.

- Дундговь аймгийн Ард телевизээр тооллогын шторкыг тогтмол давтамжтайгаар цацаж олон нийтэд хүргэж байгаа бөгөөд мөн телевизийн 20 цагийн мэдээллийн хөтөлбөрт ярилцлага өгч сурталчиллаа. Хэлтсийн албан ёсны цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудас, аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн программ ABLE-





н олон нийтийн хэсэгт байршуулан мэдээллийг олон нийтэд хүргэлээ. Аймгийн онцгой байдлын газрын АС цогцолбор мэдээллийн радиогоор малчидад тооллогын мэдээллийг хүргэн, тооллогод хамрагдахыг уриаллаа.

- Байшин орон сууцны тооллого, Хүн ам, өрхийн мэдээллийн шинэчилсэн бүртгэл, Хүн ам орон сууцны улсын тооллогын хүрээнд аймгийн төв зам дагуу 3х6 хэмжээтэй самбарыг байршуулж иргэн бүрийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж тооллого судалгаандаа идэвхитэй хамрагдахыг уриаллаа.




- Байшин орон сууцны тооллого явагдаж буй аймгийн бүх сумдад тооллогын зорилго ач холбогдолыг багтаасан зурагт хуудас, брошур постерийг тараан иргэдэд сурталчлан таниулж ажиллаж байна.



4. Хүн ам орон сууцны тооллогын сурталчилгаа

Монгол Улсын хэмжээнд 10 жил тутам зохион байгуулагддаг Хүн ам орон сууцны ээлжит тооллого 2020 онд зохион байгуулагдах гэж байна. Уг тооллогын сурталчилгааг дараах байдлаар хийлээ.

1. Хүн ам, орон сууцны тооллогын тухай Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 5-ний өдрийн 1/1346 хасралт бүхий албан бичгийг СУМ, ХЭЛТЭС, АГЕНТЛАГИЙН дарга нарт хүргүүлж, төрийн байгууллагын ажилтнуудад иргэн өөрийн мэдээллийг шалгах талаарх албан бичгийн хэрэгжилт, тайланг байгууллагуудаас авч ажиллаж байна.



2. Аймаг, сумдын тооллогын комиссын дарга, гишүүдэд ХАОСТ-ын хууль эрх зүй, зохион байгуулалт, тоологч, шалгагчийн үүрэг, хариуцлагын талаарх сургалтыг 80


Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

хүнд зохион байгуулж, сумдыг 7 хоног бүр тайлан, төлөвлөгөө өгч ажиллах чиглэл өглөө.

3. Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын олон нийттэй харилцах хэлтэс болон АРД телевизээр тооллогын 2 төрлийн шторкыг 12 удаагийн давтамжтайгаар эфирээр цацаж, олон нийтэд хүргэж байгаа бөгөөд мөн телевизийн 20 цагийн мэдээллийн хөтөлбөрт Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын зохион байгуулалт, онцлог, иргэдийн үүрэг оролцооны талаар ярилцлага өгч сурталчиллаа. Дундговь аймгийн Ард телевиз нь тус аймгийн 45000 иргэд олон нийтэд цацагдахаас гадна Юнивишн, Дидиш кабелийн телевизээр орон



даяар цацагддаг юм.



Хэлтсийн албан ёсны цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудас, аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн программ ABLE-н олон нийтийн хэсэгт байршуулан мэдээллийг олон нийтэд хүргэлээ.



Онцгой байдлын газрын дэргэдэх Аюулаас сэрэмжлүүлэх цогцолбор 107,5 ФМ-ээр өдөрт 5-7 удаа аудио хэлбэрээр, масс мессэжийг эхний удаа 400 ард иргэд, малчдад мэдээллийг хүргэж ажиллаж байна.

Онцгой байдлын АС цогцолбор нь 2015 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба Дундговь аймгийн хэмжээнд бүх сумдад хүрдэг радио FM бөгөөд малчдад хамгийн ойр мэдээллийн хэрэгсэл юм.

4. Хүн ам, өрхийн мэдээллийн шинэчилсэн бүртгэл, Хүн ам орон сууцны улсын тооллогын хүрээнд аймгийн төв зам дагуу 3х6 хэмжээтэй самбарыг байршуулж иргэн бүрийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж тооллого судалгаандаа идэвхитэй хамрагдахыг уриаллаа.



5. Хүн ам орон сууцны тооллогын зорилго ач холбогдолыг багтаасан брошурыг Дундговь аймгийн 15 суманд 300 ширхэг, (1 суманд 20 ширхэг) сургууль, цэцэрлэгүүдэд 630 ширхэг, ил захидал 100 ширхэг, стикерийг аймаг сумын хэмжээнд 7000 ширхэг, постерийг 100 ширхэг тус бүр тараан иргэдэд сурталчлан таниулж ажиллаж байна. (Хүснэгт-1)



Хүснэгт-1

| д/д | Сурталчилгааны материалын нэр | Тараасан материалын тоо | Хэмжих нэгж /ширхэг/ |
|-----|-------------------------------|-------------------------|----------------------|
| 1 | Брошур | 930 | Ш |
| 2 | Ил захидал | 100 | Ш |
| 3 | Стикер | 7000 | Ш |
| 4 | Постер | 100 | Ш |
| 5 | Баннер | 1 | Ш |

Мөн аймгийн томоохон худалдааны төвүүд болон бусад үйлчилгээний газруудад зурагт хуудас болон стикрийг нааж, ард иргэдэд сурталчилж ажиллаж байна.

6. ХАОСТ-ын зорилго ач холбогдлыг таниулах үүднээс аймгийн төвийн коллеж, сургуулуудын нийт 300 гаруй оюутан, сурагчдыг сургалтанд хамруулж,



Статистикийн тухай ойлголт, статистик мэдээллийн хэрэглээ, ач холбогдол, Статистик мэдээллийн нэгдсэн сан сайтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, харьяа багийн засаг дарга хандах буюу <http://registration.nso.mn> линкээр орж Хүн ам өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн бүртгэлдээ хамрагдахыг уриалж, брошур тараалаа.

Бусад сурталчилгааны ажил

Дундговь аймаг 2019 оныг “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” жил болгон зарласан бөгөөд тус нэрэлсэн жилд зориулан дараах иргэдэд чиглэсэн сурталчилгааны ажлуудыг хийлээ.



1. Төрийн албан хаагчид болон ААНБ-ын ажилтнууд, иргэд Статистик мэдээллийг цахимаар түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлж Статистик мэдээллийн нэгдсэн сан болон аймгийн вэб сайтын хаяг бүхий наадаг стикер буюу мэдээллийн хөтчийг хэвлэн тархааж байна. Эхний хагас жилийн байдлаар 615 ширхэгийг хэвлэн олон нийтэд түгээж, Статистик мэдээллийн нэгдсэн санг сурталчилжээ.



2. Сүүлийн 10 жилийн аймгийн нийгэм, эдийн засгийн мэдээллийн өврийн дэвтрийг 2018 оны мэдээллээр шинэчлэн хэвлэж Засаг даргын шуурхай хурал дээр танилцуулан, аймаг, сумдын удирдлагууд, хэлтэс агентлагийн дарга нар болон ИТХ-ын тэргүүлэгчдэд нийт 200 ширхэгийг тархаалаа. Мөн файл болон зурган хэлбэрээр цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудсаар олон нийтэд түгээн ажиллалаа.



3. Сар бүрийн бюллетень танилцуулгын прэсэнтэйшнийг шинэлэг өнгө дизайнаар сонирхолтой инфографик ашиглан шинэчлэн хийж аймгийн Засаг даргын тамгын газрын олон нийттэй харьцах албанд хүргүүлэн ЗДТГ-ын иргэдийн хүлээлгийн танхим дахь тв-ээр сар бүрийн 12-15 өдрүүдэд тодорхой давтамжтайгаар явуулж иргэдэд мэдээллээ хүргэж байна.



Монгол Улсад Статистикийн алба үүсч хөгжсөний 95 жилийн ойд зориулан хийсэн сурталчилгааны ажлууд

1. Нээлттэй мэдээллийн өдөрлөг

Статистикийн салбарын хууль эрх зүй, арга аргачлалыг олон нийтэд таниулах, мэдээллийн чанарыг сайжруулах, Статистик мэдээ мэдээллийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 10 сарын 21-28 өдрүүдэд 7 хоногийн туршид Дундговь аймгийн төр, захиргааны байгууллага, аж ахуй нэгж, нийт багийн дарга нар, сумдын Статистик хариуцсан ажилтнууд болон аймгийн

МОНГОЛ УЛСАД СТАТИСТИКИЙН АЛБА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 95 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

Зорилго: Монгол Улсад Статистикийн алба үүсч хөгжсөний 95 жилийн ой, Иргэн төвтэй Төрийн үйлчилгээний жилд зориулан Статистикийн салбарын хууль эрх зүй арга аргачлалыг олон нийтэд таниулах, мэдээллийн чанарыг сайжруулах, Статистик мэдээ мэдээллийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх

Хамрах хүрээ: Дундговь аймгийн төр, захиргааны болон, аж ахуй нэгж байгууллага багийн Засаг дарга нар, сумдын Статистик хариуцсан ажилтнууд, аймгийн нийт иргэд.

Хугацаа: 2019 оны 10 сарын 21-28 өдрүүд /7 хоног/
Өдөрлөгөөр зохион байгуулагдах үйл ажиллагаа болон чиглэл:

- Аймгийн нийгэм эдийн засгийн мэдээллүүдийг багтаасан өөрийн дэвтэр, статистикийн салбарын хууль эрх зүй, Статистик мэдээллийн инфографик нугалбаруудыг хэрэглэгчдэд тархах
- Статистикийн хүн ам өрхийн мэдээллийн сан буюу ХАӨМСан дахь өөрийн болон гэр бүлийн мэдээллээ шалгах <http://registration.nso.mn> линкийг сурталчилан иргэдийн мэдээллийг шалгах, шинэчлэх
- Аж ахуй нэгжүүдэд Статистик мэдээг цахимаар өгөхийг уриалах, хэрэглэгчдийг бүртгэх <http://medee.1212.mn/>
- Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ийг болон хэлтсийн албан ёсны цахим хуудас www.dundgovi.nso.mn сагтуудыг сурталчилах, иргэдэд Сонирхолтой статистикийг хэвлэж өгөх
- Статистикийн салбарын хүний нөөцийн судалгааг бүрдүүлэх зорилгоор Статистикийн мэргэжилтэй иргэдийн анкетийг хүлээж авах
- Статистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх сайжруулах зорилгоор багийн дарга нар болон Сумдын Статистик хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах /10 сарын 22, 23/
- Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан Инфографикийн уралдаан болон сумдын Статистикийн өөрийн дэвтрийн уралдааны дүнг гаргаж шагналыг гардуулах
- ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын "Үдийн хоол 2020" юу идэх вэ, илчлэг үү, шим тэжээл үү? Сэдэвт материал загварчлалын хоёрдугаар уралдааныг сурталчилах
- Сумдын тооллогын комисс, Багийн түр товчоодын дунд ХАӨМСан дахь мэдээллээ шалгах <http://registration.nso.mn> линк-ийг сурталчилан иргэдийг хамруулах 2 сарын аяныг зарлах/10.21-12.21 хооронд/

Иргэд олон нийт та бүхэн идэвхитэй оролцоно уу

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

иргэд олон нийтэд чиглэн зохион байгууллаа. Өдөрлөгөөр удирдамжид тусгагдсан үйл ажиллагаанууд зохион байгуулагдсан.



7 хоногийн хугацаатай зохион байгуулсан өдөрлөгийн нэгдсэн Нээлттэй мэдээллийн өдрийг 10 сарын 25-нд Сайнцагаан сумын Хүн ам орон сууцны тооллогын комисстой хамтран Сайнцагаан сумын ЗДТГ-ын Иргэний танхимд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэдэд статистикийн салбарын хууль эрх зүйн орчин, тооллого, судалгаа, статистик мэдээллийн аргачлал, арга зүйн талаар болон Статистикийн байгууллага, хэлтсийн үйл ажиллагаагаа сурталчлахын зэрэгцээ Сайнцагаан сумын багийн засаг дарга нартай хамтран иргэдийн ХАӨМСангийн мэдээллийг шалган, шинэчлэж ажиллалаа. Нийтдээ 50 гаруй өрхийн 120-н хүний мэдээллийг ХАӨМСанд шинэчиллээ.



Өдөрлөгийн үеэр инфографикийн уралдаанд амжилттай оролцсон байгууллагуудад шагнал гардуулсан юм. Нээлттэй мэдээллийн өдрөөр удирдамжийн дагуу ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын “Үдийн хоол 2020” юу идэх вэ, илчлэг үү, шим тэжээл үү? Сэдэвт математик загварчлалын хоёрдугаар уралдааны 50 сурталчилгааны хуудсыг тарааж, 30 иргэнд сонирхолтой Статистикийг хэвлэж өгч, 32 ААН-ийг онлайнаар мэдээ өгөхөөр бүртгэж авч, registration.nso.mn линк, www.medee.1212.mn линкүүдийг сурталчилсан 250 брошурыг иргэд, олон нийтэд түгээсэн байна.



2. Инфографик болон өврийн дэвтрийн уралдаан

1. Монгол улсад Статистикийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ой, Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн ажлын хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийг иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй хүргэх, Статистикийн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлж, ач холбогдлыг ойлгуулах зорилгоор Статистикийн хэлтсээс


Статистик мэдээллийн өврийн дэвтрийг хэлтсийн албан ёсны цахим хуудсанд байршуулахаар хянах ажил хийгдэж байна.

Ш10.3 Мэдээлэл тархаалт, вэб баяжилт

Ш10.3.1 Байгууллагын вэб танилцуулга, БТ- Бюллетень, танилцуулга

Хэлтсийн вэб хуудсыг шинэчлэн хууль тогтоомж, цаг үеийн шинэ мэдээ, мэдээлэл, Нийгэм, эдийн мэдээллийг тогтмол оруулж ажиллалаа. 2019 онд байдлаар шинээр 52 удаа цаг үеийн шинэ мэдээ мэдээлэл оруулж, хандалтын тоо жил бүр нэмэгдэж одоогийн байдлаар 2019 онд 1.003.044 хүн шинээр хандалт хийж мэдээлэл үзсэн байна. Хэлтсийн вэб хуудсанд “Дундговь аймгийн Статистикийн хэлтэс” нэртэй 2163 гишүүдтэй Page хуудсыг холбож иргэдэд үйлчилж байна.

ВЭБ ХУУДСАНД ХАНДАЛТ ХИЙСЭН ХҮНИЙ ТОО



Сар бүрийн бюллетень, танилцуулгыг дараа сарын 12-ны дотор хэлтсийн вэб хуудаст тогтмол байршуулж ирлээ. 2019 онд 12 удаа сарын танилцуулгыг бэлтгэж танилцуулгын цэсэнд байршуулаад байна.

САР БҮРИЙН ТАНИЛЦУУЛГА

| Он | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар |
|------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| 2014 | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word |
| 2015 | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word |
| 2016 | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word | excel word |
| 2017 | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах |
| 2018 | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах |
| 2019 | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах | татах |

ТУСЛАХ ЦЭС

- Мэдээний маяг
- Инфографик
- Хэлтсийн даргын тушаал

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ
2019.12.11-ны байдлаар /төгсөг/

| | | |
|------------------|----|------|
| Гурил, I зэрэг, | кг | 1300 |
| Хонины мах, | кг | 7000 |
| Үхрийн мах, | кг | 0 |
| Ямааны ястай мах | кг | 6000 |
| Элсэн чихэр, | кг | 1950 |
| Цагаан будаа, | кг | 2420 |
| Шингэн сүв, | л | 3500 |

Ш10.3.2 ДҮ-Динамик үзүүлэлт, бүрдүүлэлт

2019 онд Аймгийн нийгэм, эдийн засгийн дараах 11 төрлийн үзүүлэлтээ шинэ оны мэдээллээр баяжуулан шинэчлэхээс гадна шинээр 5 төрлийн динамик хийж олон нийтэд хүргэж, үйлчилж ажиллалаа. Үүнд:

1. Хүн ам, өрх, нийгмийн зарим үзүүлэлтүүд /1996-2018, сумын түвшинд/
2. Хүн ам, өрх багаар /2008-2018 багийн түвшинд/
3. Малын тоо /1942-1980 аймгийн түвшинд, 1980-2018, сумын түвшинд/
4. Төл бойжилт, /1980-2018, сумын түвшинд/
5. Хээлтэгч, /1980-2018, сумын түвшинд/
6. Том малын хорогдол /1980-2018, сумын түвшинд/
7. Эрүүл мэнд /1998-2018, сумын түвшинд/
8. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /1997-2018 он, аймгийн түвшинд, гол нэр төрлийн бүтээгдэхүүний мэдээллээр баяжуулсан/
9. Бүртгэлтэй ажилгүйчүүд /2001-2018 он, сумын түвшинд/
10. Бүртгэлтэй аж ахуй нэгж /1998-2018 он, сумын түвшинд/
11. Хот нийтийн аж ахуйн үзүүлэлт /1997-2018, сумын түвшинд /
12. Нийгмийн зарим үзүүлэлт /2010-2018 он, багийн түвшинд/
13. Хүн амын дундаж наслалт /1992-2018 он, аймгийн түвшинд/-**шинэ**
14. Газар тариалан / 2001-2018 Сумын түвшинд /-
15. Барилга угсралт, их засварын ажил / 2006-2018 аймгийн түвшинд /
16. Дотоодын нийт бүтээгдэхүүн / 2000-2018 аймгийн түвшинд /
17. Бүртгэлтэй аж ахуй нэгж / 1998-2018 Сумын түвшинд /
18. Гэмт хэрэг/ 2010-2018 аймгийн түвшинд /-**шинэ**
19. Боловсрол / 2010-2018 Сумын түвшинд /-**шинэ**
20. Төсөв санхүү / 2010-2018 Сумын түвшинд /-**шинэ**
21. Банк / 2009-2018 аймгийн түвшинд /-**шинэ**

Ш10.3.3 ЖЭ- Жилийн эмхэтгэл

Аймгийн Статистик мэдээллийн жилийн эмхэлтгэлийг 5 бүлэг, 46 дэд бүлэгтэйгээр цахимаар бэлтгэн хэлтсийн вэб хуудсанд байршуулж тархаалаа. Мөн өврийн дэвтрэ аймаг, сумдаар бэлтгэн хэвлэмэл 200 ширхэг тархааж, хэлтсийн вэб хуудсаар тархаасан.



| ӨВРИЙН НОМ | | |
|---|---------|---------|
| Аймаг, сумдын өврийн ном | 2017 он | 2018 он |
| Аймгийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл | татах | татах |
| Сайнцагаан сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Адаацаг сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Дэлгэрцогт сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Хулд сумын нийгэм эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Баянжаргалан сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Дэлгэрхангай сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Дэрэн сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Өндөршил сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |
| Эрдэнэдалай сумын нийгэм, эдийн засгийн мэдээлэл | | татах |


| ТУСЛАХ ЦЭС | | |
|------------|------------------------|--|
| | Мэдээний маягт | |
| | Инфографик | |
| | Хэлтсийн даргын тушаал | |

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ
2019.12.11-ны байдлаар / төгрөг /

| | | |
|-----------------|----|------|
| Гурил, I зэрэг, | кг | 1300 |
| Хонины мах, | кг | 7000 |
| Ухрийн мах, | кг | 0 |

Ш10.3.4 СТ- Салбарын танилцуулга

Хөдөө аж ахуй, Өрх, хүн ам, Барилга, аж үйлдвэр, Хүн ам ажил эрхлэлт, ажилгүйдлийн 2018 оны танилцуулгыг хэлтсийн вэб хуудсанд байршуулаад байна.




Ш10.3.5 Инфографик мэдээлэл

2019 онд аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр дараах 36 төрлийн инфографик бэлтгэн хэлтсийн вэб хуудас, олон нийтийн сүлжээгээр болон хэвлэж олон нийтэд тархаалаа.

- Мал тооллогын дүн мэдээлэл 2018 монгол, англи хэлээр
- Ажил эрхлэлт -2018
- Сумдын өрх хүн ам, малын тоо, малчин өрхийн мэдээлэл
- Дундговь аймгийн эмэгтэйчүүд-2018
- 2019 оны 1-р улирлын инфографик
- Аймгийн өрх хүн амын инфографик 2018
- Дундговь аймгийн хүүхдүүд инфографик 2018
- Сумдын 2018 оны нийгэм, эдийн засгийн мэдээллээр 15-н инфографик
- Аймгийн нэгдсэн инфографик-2018
- Сарын прэнсэнтэйшний инфографик





IV БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

22. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш11)

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн дотоод ажил үүргийн хуваарийн дагуу хэлтсийн ажилтнууд үндсэн ажлаас гадна дараах байдлаар нэмэлт ажил хариуцан ажиллаж байна. /Хүснэгт-10/

Хүснэгт 10. Хэлтсийн дотоод ажил үүргийн хуваарь

| Дотоод ажил үүрэг | Албан тушаал | Хариуцах ажилтан |
|---|-------------------|-----------------------------|
| 1 Удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, орон нутгийн удирдлагуудад мэдээ, мэдээлэл хийх, | Хэлтсийн дарга | Б.Энхтуяа |
| 2 Төлөвлөлт, тайлагналт, хяналт шалгалт олон нийтийн сүлжээнд мэдээ, мэдээлэл хийх | Ахлах мэргэжилтэн | Т.Бямбасүрэн |
| 3 Техник хангамж, вэб баяжилт, спорт арга хэмжээ | Мэргэжилтэн | Н.Түвшинжаргал |
| 4 Гэр бүлийн зөвлөл | Мэргэжилтэн | С.Доржханд |
| 5 Архив бичиг хэргийн бүртгэл, хөтлөлт | Мэргэжилтэн | Н.Тамжидмаа |
| 6 Нярав, хэвлэн тархаалт | Зохион байгуулагч | ХАОСТ-ын гэрээт Д.Чогсомжав |
| 7 Нягтлан бодогч | Судлаач | Г.Болормаа |

| | | | |
|---|--------------------------|---------|-------------|
| 8 | Спорт олон нийтийн ажил | Судлаач | Э.Гантулга |
| 9 | Урлаг, олон нийтийн ажил | Судлаач | Н.Тамжидмаа |

Ш11.1 Төлөвлөлт, тайлагналт

ҮСХ-ноос ирүүлсэн загварын дагуу нэгжийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж тогтоосон хугацаанд хүргүүлсэн. 2019 оны эхэнд бичиг хэргийн стандарт шаардлагын тухай сургалт зохион байгуулан, тайлан төлөвлөгөө болон хэлтсээс гарч буй бүх албан бичгүүдийг бичиг хэргийн стандартын дагуу боловсруулж хэвшээд байна.

Тухайн жилд хэрэгжүүлэх хууль, тогтоол, шийдвэр, үндэсний хөтөлбөр, ҮСХ-ны чиглэл, тушаал, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийн биелэлтэд байнга хяналт тавьж, биелэлтийг тогтмол цаг хугацаанд нь гаргаж мэдээлж ажиллаж байна. 2019 онд дараах тогтоол шийдвэр, захирамж, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна

Хүснэгт 10. 2019 онд зайлшгүй хэрэгжүүлэх тогтоол, шийдвэрийн биелэлт.

| | Огноо | № | Тогтоол шийдвэрийн агуулга | Хэрэгжих заалтын тоо | Хэрэгжилт | |
|---------------------------------------|---|--------|--|----------------------|-----------|-----------------|
| | | | | | Биелсэн | Хэрэгжиж байгаа |
| А | Засгийн газрын тогтоол | | | | | |
| Б | ҮСХ-ны даргын тушаал, чиглэл | | | | | |
| 1 | 2018.12.31 | A/159 | Статистикийн 2019 оны мэдээ, тайлангийн графикийг батлах тухай | 1 | | 1 |
| ҮСХ-ны Тамгын газраас ирүүлсэн чиглэл | | | | | | |
| 2 | 2019.01.11 | 03/41 | Чиглэл хүргүүлэх тухай | 1 | 1 | |
| 3 | 2019.04.25 | 06/357 | Чиглэл хүргүүлэх тухай | 1 | | 1 |
| В | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ЭЗН-г хөгжүүлэх үндсэн чиглэл | | | | | |
| 4 | 2019.08.29 | 129 | Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл | 2 | | 2 |
| 5 | | | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр | 2 | | 2 |
| Г | Аймгийн Засаг даргын захирамж | | | | | |
| 6 | 2019.03.01 | A/85 | “Хүн ам орон сууцны тооллого зохион байгуулах тухай” | 4 | 3 | 1 |
| 7 | 2019.01.01 | A/01 | 2019 оныг “Бүтээн байгуулалт иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарлах тухай” | 4 | - | 4 |

| | | | | | | |
|------|------------|------|---|----|---|----|
| 8 | 2019.02.28 | А/84 | 3000 морин хуурч уртын дуучдын тоглолт зохион байгуулах тухай | 1 | - | 1 |
| Нийт | | | | 16 | 4 | 12 |

Ш11.2.Засаг даргын үнэлгээ

2018 оны Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үнэлгээ 91,56 /А/, Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн үйл ажиллагааны хяналт шалгалтаар Хэлтсийн 2018 оны үйл ажиллагаа 90,02 /А/ буюу санаачлагатай сайн үнэлэгдсэн болно. Засаг даргын захирамжаар хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнийг 1 сарын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр шагнаж урамшуулсан. 2019 оны Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнүүлэх шатандаа явж байна.

Ш11.3.Шинэ санаа, санаачилга

2019 онд хэлтсийн бүх ажилчдыг улирал бүр шинэ санал, санаачилга гарган ажиллах үүрэг даалгаврыг хэлтсийн даргын зүгээс өгч, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ онд ажилчдаас гарсан шинэ санал санаачилгуудыг нэгтгэн авч үзвэл 3 ажил үндсэн статистик мэдээллийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн байсан бөгөөд мэдээний ирц, дамжуулалт, ХАӨМС-ийн баяжилтын тайланд орсон, 2 ажил нь ХАОСТ-2020 сурталчилгааны ажил, 4 ажил нь вэб баяжилт, инфографик, мэдээлэл тархаалтын мэдээллийн хөтөч стикерийг сурталчилгааны ажлын тайланд тусгагдсан, 1 ажил сумдын анхан шатны мэдээний чанарыг сайжруулах зорилгоор бүх сумдад хавтас нээн өгсөн бөгөөд бусад шинэлэг ажлууд нь хэлтсийн дотоод тохижилт, ажлын байрны тохижилттой холбогдолтой санал санаачилга байлаа. Үүнд:

Анхан шатны Статистик мэдээний чанарыг сайжруулах чиглэлээр сумдын Статистик хариуцсан албан хаагчдад сумын инфографик, мэдээний баримтжуулалт, ирсэн явсан бичиг зэргийг бүртгэх зорилготой хавтас нээж өглөө.

Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд бичиг баримтын стандартыг хэлтсийн ажилчдад мөрдүүлэх зорилгоор стикер бэлтгэж ширээн дээр нь нааж өглөө.



| Статистикийн хэлтэс | | Сүхбаатар аймгийн | | Дархан-Уул аймгийн | | Өвөрхангай аймгийн | | Говь-Алтай аймгийн | | Дорнод аймгийн | | Дундговь аймгийн | | Дундговь аймаг | |
